

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ
ХАНГАХ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2023 оны 12 сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Байгууллагын төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт	Хугацаа	Хэрэгжилтийн хувь
	1	2	3	4	5	6
НЭГ. ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН ТАЛААР						
1.	Газрын бүтэц, нэгжүүдийн үйл ажиллагааг сайжруулах, сул орон тоог хууль тогтоомжийн дагуу нөхөх ажлыг зохион байгуулж ажиллана	1.	Газрын албан тушаалын сул орон тоо, эзгүй байгаа албан хаагчдыг Төрийн албаны нөөцөөс нөхөх, мэргэшлийн шалгалт зарлах, сонгон шалгаруулж томилох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу ил тод, нээлттэй зохион байгуулах	Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.4 дэх хэсэгт заасны дагуу Нийслэлийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын Төрийн захиргааны дэс түшмэлийн 5 албан тушаалын сул орон тооны мэдээллийг 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 01/259, 23023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 01/554 дүгээр албан бичгээр Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлж сул орон тоо нөхөх сонгон шалгаруулалт зарлуулж ажилласан.	I-IV улирал	100 хувь
		2.	Газрын албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан, холбогдох мэдээллийг “Хүний нөөцийн систем”-д шинэчлэн оруулах	Нийслэлийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын ажиллаж байгаа болон ажлаас түр чөлөөлөгдсөн нийт 84 төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөнийг төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн системд хөтөлж, мэдээллийг шинэчлэн ажилласан.	I-IV улирал	100 хувь

ХОЁР. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН САХИЛГА, ХАРИУЦЛАГЫГ САЙЖРУУЛАХ, ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР						
2.	Төрийн албан хаагчдыг төлөвшүүлэх, гүйцэтгэлийг үр дүнд суурилсан үнэлэх хэлбэрийг хэвшүүлэх замаар төрийн албаны стандартыг хэрэгжүүлж ажиллана	3.	Албан хаагчидтай төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хөдөлмөрийн гэрээ байгуулж, хэрэгжилтийг тооцож, үр дүнд суурилсан хэлбэрээр үнэлж, дүгнэх, мөнгөн урамшуулал олгох	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, мэргэжлийн түвшинг үнэлэх журмын дагуу байгууллагын албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хөдөлмөрийн гэрээний хэрэгжилтийг тооцож Нийслэлийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/30 болон 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/51 дүгээр тушаалаар Үнэлгээний баг байгуулан албан хаагчдын ажлын үр дүнг үнэлэн мөнгөн урамшуулал олгосон.	I-IV улирал	100 хувь
		4.	Газрын албан хаагчдын баримтлах ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, хяналт, хариуцлагын тогтолцоог дотооддоо бүрдүүлж ажиллах	Монгол Улсын төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд Байгууллагын “Ёс зүйн дэд хороо” болон дэд хорооны ажиллах дүрмийг шинээр боловсруулж Газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн А/34 дүгээр тушаалаар батлуулж мөн даргын зөвлөлийн хуралд нийт албан хаагчдад тус хууль болон Ёс зүйн дэд хорооны ажиллах дүрмийг танилцуулсан.	I-IV улирал	100 хувь
		5.	Албан хаагчдын ажлын үр дүн, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжид хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллах	Нийслэлийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын нийт албан хаагчдын ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор бага насны хүүхэдтэй болон хүндэтгэн үзэх шалтгаантай албан хаагчдын хүсэлтээр ажлын цагийн эхлэх төгсөх горимд өөрчлөлт оруулж газрын даргаар батлуулан мөрдүүлж ажилласан. Мөн хуулиар олгосон ажлийн цагаас илүү цагаар ажилласан ажилтан албан хаагчдад 2023 оны 12 дугаар сард илүү цагийн урамшуулал олгож үр дүнг тооцон ажилласан.	I-IV улирал	100 хувь
ГУРАВ. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР						

3.	Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хүрээнд албан хаагчдын нийгмийн асуудлыг судлан шийдвэрлэх, шагнаж урамшуулах асуудлыг шат дараатай зохион байгуулж ажиллана	6.	Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан нэмэгдэл хөлс, зэрэг дэв ахиулах асуудлыг судлан шийдвэрлэх	Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан нэмэгдэл хөлс, зэрэг дэв ахиулах асуудлыг судлан төрийн захиргааны 23 албан тушаалтанд Нийслэлийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн Б/75 дугаар тушаалаар төрийн жинхэнэ албан хаагчийн зэрэг дэвийг нэмэгдүүлэн олгосон.	I-IV улирал	100 хувь
		7.	Албан хаагчдаас ээлжийн амралтын хуваарийн саналыг авч, Газрын даргын тушаалаар ээлжийн амралтын хуваарийг батлуулж, ээлжийн амралтын олговрыг тухай бүр олгох	Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу Нийслэлийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын нийт албан хаагчдын 2023 оны ээлжийн амралтын хуваарийн саналыг нэгтгэн авч, Газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/03 дугаар тушаалаар албан хаагчдын ээлжийн амралтын хуваарийг баталж албан хаагчдыг биеэр амруулсан. Ажлын зайлшгүй шаардлагаас үүдэн 1 албан хаагч ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй тул Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу цалин хөлсийн 1.5 дахин нэмэгдүүлж мөнгөн урамшуулал олгож шийдвэрлэсэн.	I-IV улирал	100 хувь
		8.	Төрийн албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор оношилгоо, шинжилгээнд хамруулах	Төрийн албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор оношилгоо, шинжилгээнд хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.	I-IV улирал	30 хувь
		9.	Тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллаж байгаа албан хаагчдад нийгмийн асуудлыг шийдэхэд нь дэмжлэг үзүүлэх	2023 оны жилийн эцсийн байдлаар улирлын байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 9.2, 9.4-д заасны дагуу 9 албан хаагчид буцалтгүй тусламж, тэтгэмж олгож нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн. Төрийн албан хаагчийн суралцах эрхийн хүрээнд Удирдлагын академийн ахлах түшмэлийн болон дунд хугацааны мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах нийт 8 албан хаагчид цалинтай чөлөө олгож сурах боломжоор ханган ажилласан. Эрх зүйн чиглэлээр сурч байгаа 2, мэргэжил дээшлүүлж байгаа 3 албан хаагчид цалинтай чөлөө олгож сурах	I-IV улирал	100 хувь

			боломжоор ханган ажилласан. Мөн төрийн албаны тухай хуулийн хүрээнд 13 албан хаагчид хувийн чөлөө олгосон байна. Нийт төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэн холбогдох журмын хүрээнд урамшуулал олгосон.		
	10.	Төрийн албан хаагчдын ажиллах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх	Нийт албан хаагчдын техник, тоног төхөөрөмжийг сайжруулж ажлын үр дүнг сайжруулах зорилгоор 15 албан хаагчийн компьютер, 15 албан хаагчийн принтерийг иж бүрэн шинэчилсэн бөгөөд нийт албан хаагчдын өрөө тасалгааг засварлаж ажиллах нөхцөлөөр хангасан байна.	I-IV улирал	100 хувь
	11.	Газрын ажилтан, албан хаагчдын бие бялдарыг чийрэгжүүлэх, хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор заал түрээслэх (долоо хоногт 1 удаа)	Газрын ажилтан, албан хаагчдын бие бялдарыг чийрэгжүүлэх, хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор долоо хоног бүрийн Баасан гарагт заал түрээслэж албан хаагчдыг харуулан ажиллаж байна.	I-IV улирал	100 хувь
	12.	Ажилтан, албан хаагчдын дунд урлаг, спортын арга хэмжээ зохион байгуулах.	2023 оны Нийслэлийн Засаг даргын харьяа агентлагуудын дунд зохион байгуулагдсан "Спорт" тэмцээнд гар бөмбөгийн төрөлд баг хамт олноороо амжилттай оролцсон.	I-IV улирал	100 хувь

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.БАЯНХУТАГ

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

М.ДАВААСҮРЭН